



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 05 сарын 25 өдөр

Дугаар А/191

Мандалговь

“Оптик Энержи” ХХК-тай гэрээ
байгуулах тухай

Монгол Улсын “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль”-ийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Засаг даргын 2019 оны 3 дугаар сарын 07-ны өдрийн А/89 дугаар захирамжаар байгуулагдсан үнэлгээний хорооны дүгнэлтийн дагуу орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжих “Адаацаг сумын ерөнхий боловсролын сургуулийн биеийн тамирын талбайн тохижилтын ажил”-ын гүйцэтгэгч “Оптик Энержи” ХХК-тай 36,993,688 (Гучин зургаан сая есөн зуун ерэн гурван мянга зургаан зуун наян найм) төгрөгөөр гэрээ байгуулсугай.

Хоёр. Батлагдсан зураг төсвийн дагуу “Адаацаг сумын ерөнхий боловсролын сургуулийн биеийн тамирын талбайн тохижилтын ажил”-ыг чанартай хийж гүйцэтгэн, хүлээлгэж өгөхийг “Оптик Энержи” ХХК-ны захирал (Б.Бадам)-д үүрэг болгосугай.

Гурав. Дээрх байгууллагатай гэрээ байгуулж, гэрээний дагуу хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс (Н.Эрдэнэ-Очир), Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар (Э.Чагнаадорж), Адаацаг сумын Засаг дарга (Ж.Батхөлөг), ажлын тайлан, гүйцэтгэлийг үндэслэн санхүүжилт олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (А.Ганбат) нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

488190524